



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 31 өдөр

Дугаар 0/384

Арвайхээр

Бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар
шилжүүлсэн хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Улсын Онцгой комиссын 2020 оны 28 дугаар хурлын тэмдэглэл, аймгийн Онцгой комиссын 2020 оны 11 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Улсын Онцгой комиссын 2020 оны 28 дугаар тэмдэглэлээр гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг сунгасантай холбогдуулан аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг 2020 оны 09 дугаар сарын 15-ны өдөр хүртэл сунгасугай.

2. Аймгийн Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/264 дүгээр захирамжийн нутаг дэвсгэрийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдаалах зохицуулалтыг хэвээр үлдээж, согтууруулах ундаа худалдах цагийг 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 09 дүгээр сарын 15-ныг хүртэлх хугацаанд 09.00-22.00 цаг байхаар хуваарийн дагуу ажиллуулж, эрүүл ахуй, аюулгүй байдлыг чанд баримтлан, мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.

3. Хязгаарлалтын дэглэмийн хугацаанд төрийн байгууллага, улсын болон орон нутгийн өмчит байгууллага, бусад аж ахуйн нэгж, иргэдээс нийтийг хамарсан аливаа арга хэмжээг зохион байгуулахад эрүүл ахуй, аюулгүй байдлыг чанд баримтлан ажиллахыг үүрэг болгосугай.

4. Захирамжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), сумдын Засаг дарга, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн) нарт даалгасугай.

ОРЛОГЧ
О.БАТЖАРГАЛ



011100859